

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУУРЬ МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТЫН ТАЙЛАН

Зохион байгуулсан үндэслэл:

Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/44 дүгээр тушаалын дагуу.

Хугацаа:

2025 оны 02 дугаар сарын 20-21-ний өдрүүд

Байршил:

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны хүндэтгэлийн танхимд

Хамрагдсан албан хаагчдын тоо:

27 хүн

Зохион байгуулсан байгууллага:

ХААСЗӨТөв ТББ

I. Сургалт зохион байгуулах болсон зорилго

Оролцогчдод худалдан авах ажиллагааны хууль эрх зүйн орчин, зохион байгуулалт, төлөвлөлт, хэрэгжилтийн үе шат, үнэлгээ болон цахим худалдан авах ажиллагааны талаар суурь мэдлэг, практик чадвар эзэмшүүлэх

II. Сургалтын агуулга

• Ерөнхий танилцуулга

- Засгийн газрын худалдан авах ажиллагааны ойлголт, онцлог
- ЗГХАА-ны ерөнхий ойлголт

✓ Хууль эрх зүйн орчин

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн танилцуулга
- Хуулийн нийтлэг үндэслэл, зарчим, нэр томьёо
- Худалдан авах ажиллагааны аргууд
- Хэлэлцүүлэг

✓ Худалдан авах ажиллагааны удирдлага

- Удирдлага, хяналт зохицуулалт
- Оролцогч талуудын үүрэг, оролцоо (Сангийн яам, Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага, захиалагч байгууллагууд, тендерт оролцогчид, иргэний нийгмийн байгууллагууд)
- Гомдол гаргах, хянан шийдвэрлэх журам

✓ **Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах**

- Төлөвлөлт, тайлагналт
- Дүн шинжилгээ хийх шалгуур үзүүлэлт
- Хэлэлцүүлэг

✓ **Худалдан авах ажиллагаатай холбоотой журам, аргачлал**

- Ерөнхий гэрээ байгуулах журам
- Бүртгэл хөтлөх журам
- Давуу эрх олгох аргачлал
- Хэлэлцүүлэг

✓ **Мэдлэг бататгах хэсэг**

- Дасгал ажил
- Тест
- Гэрийн даалгавар

III. Сургалтын үр дүн

- Оролцогчид хуулийн гол агуулга, хэрэгжилтийн талаар суурь мэдлэг эзэмшсэн.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, шалгаруулалт, гэрээний хэрэгжилтийн үе шатанд гардаг эрсдэл, хүндрэл-ийг таньж мэдсэн.
- Хууль хэрэгжүүлэх явцад тулгардаг бодит нөхцөл байдал, практик асуудлуудыг хамтад нь хэлэлцсэн.
- Цаашид байгууллага бүрийн онцлогт нийцсэн гүнзгийрүүлсэн сургалтын хэрэгцээ байгааг тогтоосон.

IV. Дүгнэлт, зөвлөмж

Сургалтын хоёр өдрийн турш оролцогчид төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үндсэн ойлголт, хэрэгжилтийн үе шат, оролцогч талуудын үүрэг оролцоо, тендер шалгаруулалтын үйл явц, гэрээний нөхцөлүүд болон цахим худалдан авах ажиллагааны талаар суурь мэдлэгтэй болж, практик дасгал, хэлэлцүүлгийн аргаар мэдлэгээ бататгасан.

V. Хавсралт

1. Сургалтын хөтөлбөр
2. Сургалтад хамрагдсан албан хаагчдын нэрс



ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ МЭРГЭШСЭН АЖИЛТАН БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Сэдэв	Хугацаа
СУРГАЛТЫН I ӨДӨР – 2025.02.20	
Засгийн газрын худалдан авах ажиллагааны эрх зүйн орчин, удирдлага зохион байгуулалт	
Суралцагчдын бүртгэх	09.00-10.00
I. Ерөнхий танилцуулга - Засгийн газрын худалдан авах ажиллагаа гэж юу вэ? - ЗГХАА-ны ерөнхий ойлголт	10.00-10.30
II. Хууль эрхзүйн орчин Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн танилцуулга Хуулийн нийтлэг үндэслэл, зарчим, нэр томьёо	10.30-11.30
Цайны завсарлага	11.30-11.40
II. Хууль эрхзүйн орчин /... үргэлжлэл/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн танилцуулга - ХАА-ны аргууд - Хэлэлцүүлэг	11.40-13.00
Үдийн завсарлага	13.00-14.00
III. Худалдан авах ажиллагааны удирдлага Худалдан авах ажиллагааны удирдлага, хяналт зохицуулалт - Худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын үүрэг, оролцоо (СЯ, Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага, захиалагч байгууллагууд, тендерт оролцогчид, иргэний нийгмийн байгууллагууд) - Гомдол гаргах, хянан шийдвэрлэх	14.00-15.00
IV. Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам - ХАА-ны төлөвлөлт, тайлагналт - Дүн шинжилгээ хийх шалгуур үзүүлэлт - Хэлэлцүүлэг	15.00-15.40
Цайны завсарлага	15.40-15.50
V. Худалдан авах ажиллагаатай холбоотой журам, аргачлал - Ерөнхий гэрээ байгуулах журам - Бүртгэл хөтлөх журам - Давуу эрх олгох аргачлал - Хэлэлцүүлэг	15.50-16.50
VI. Хичээлээр олж авсан мэдлэгээ бататгах зорилгоор дасгал ажил, тест гэрийн даалгаварт өгөх	16.50-17.00
СУРГАЛТЫН II ӨДӨР – 2025.02.21	

Тендер шалгаруулалтыг зохион байгуулах	
I. Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа • Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам • Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, ёс зүйн асуудлууд • Хэлэлцүүлэг	09.00-10.00
II. Тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулах • Тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийг хэрхэн ашиглах вэ? • Тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн төрлүүд	10.00-10.30
Цайны завсарлага	10.30-10.40
II. Тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулах /...үргэлжлэл/ • Тендер шалгаруулалтын баримт бичгийн агуулга • Техникийн тодорхойлолт бэлтгэх • Инкотермс • Хэлэлцүүлэг	10.40-12.30
Үдийн завсарлага	12.30-13.30
III. Гэрээний нөхцөлүүд • Гэрээний ерөнхий нөхцөл /ажил, бараа, үйлчилгээ/ • Гэрээний тусгай нөхцөлүүд /ажил, бараа, үйлчилгээ • Хэлэлцүүлэг	13.30-13.45
IV. Тендерийн үнэлгээ • Үнэлгээний зарчмууд • Үнэлэх үйл явц • Зөвлөмж /маягтууд/ • Хэлэлцүүлэг	13.45-15.00
Цайны завсарлага	15.00-15.10
V. Цахим худалдан авах ажиллагаа • Цахим худалдан авах ажиллагааны ерөнхий ойлголт, системийн танилцуулга • Цахим худалдан авах ажиллагааны журам • Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, урилга, үр дүнг нийтлэх • Худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулах • Анхаарах асуудлууд	15.10-17.00

СУРГАЛТЫН ТАЙЛАН

1. Ерөнхий мэдээлэл

- **Сургалтын нэр:** Худалдан авах ажиллагааны тухай хууль, журам, жишиг баримт бичгийн шинэчлэлтэй холбоотой сургалт
- **Зохион байгуулсан байгууллага:** Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Сангийн яам
- **Хаана зохион байгуулагдсан:** Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Хүндэтгэлийн танхим
- **Хугацаа:** 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр 9 цаг 30 минутаас 16 цаг хүртэл
- **Хамрагдсан байгууллага:** Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагууд (Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, И Монгол Академи, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Радио телевизийн үндэсний сүлжээ, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв, Үндэсний дата төв, Монголын Цахилгаан Холбоо ХК, Монгол шуудан ХК, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Мэдээлэл, технологийн Үндэсний Парк)
- **Оролцогчид:** Яамны харьяа, салбар байгууллагуудын 52 албан хаагчид сургалтад хамрагдсан.

2. Сургалт зохион байгуулах болсон үндэслэл:

Сангийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/98 дугаар тушаалаар холбогдох тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг, журамд өөрчлөлт орсонтой холбоотойгоор худалдан авах ажиллагааг хариуцсан албан хаагчдыг шинэчлэгдсэн эрх зүйн зохицуулалтад танилцуулах, мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх шаардлага үүссэн. Үүнтэй холбогдуулан Сангийн яамнаас дээрх чиглэлээр сургалт зохион байгуулсан бөгөөд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагаа хариуцсан албан хаагчид тус сургалтад хамрагдав.

3. Сургалтын зорилго

Худалдан авах ажиллагааны холбогдох хууль, журамд орсон өөрчлөлтийн агуулга, хэрэгжилтийн онцлогийг ойлгох, тендерийн баримт бичиг, үнэлгээний үйл ажиллагаанд шинэчлэгдсэн шаардлагыг зөв хэрэглэх мэдлэгийг олгох.

4. Сургалтын агуулга

Сургалтын үеэр дараах гол сэдвүүдийг хамрав.

- Худалдан авах ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын онцлог
- Сангийн сайдын А/98 дугаар тушаалаар батлагдсан шинэ журам, жишиг баримт бичгийн өөрчлөлт
- Тендерийн баримт бичгийн шинэ загвар, үнэлгээний аргачлал

- Гомдлын шийдвэрлэлт, хяналт, тайлагналын зохицуулалт
- Худалдан авах ажиллагааны цахим системийн шинэчлэл
- Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах
- Тендер

5. Оролцоо, үр дүн

- Сургалтад идэвхтэй оролцож, шинэ журам, шаардлагын талаар тодорхой ойлголт авсан.
- Тендерийн үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх шинэ загвар, шаардлагыг ойлгож, ажлын байрандаа хэрэгжүүлэхэд бэлэн болсон.
- Цаашид байгууллагын хэмжээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэв:
 1. Тендерийн баримт бичгийн шинэ загварыг хэрэглэх
 2. Үнэлгээний комиссын үйл ажиллагаанд сургалтаар авсан мэдлэгийг нэвтрүүлэх
 3. Гомдол, тайлангийн бүрдүүлэлт, ил тод байдлыг сайжруулах

6. Дүгнэлт

Сангийн яамнаас зохион байгуулсан энэхүү сургалт нь мэдээлэл сайтай, практик туршлага дээр тулгуурласан, үр өгөөжтэй болж өнгөрлөө. Сургалтын явцад оролцогчид хоорондоо санал солилцож, тулгамдаж буй асуудлуудаа хэлэлцэн, холбогдох хуулийн заалт, журамд нийцүүлэн хэрхэн шийдвэрлэх талаар мэргэжлийн хэлэлцүүлэг, харилцан яриа өрнүүлсэн нь онцлог байв. Мөн жишээ баримт бичиг, тендерийн үнэлгээний кейсүүд дээр ажиллаж, бодит нөхцөлд хэрэглэх аргачлалд суралцсан нь мэдлэгээ гүнзгийрүүлэх, ажлын туршлагаа сайжруулахад чухал ач холбогдолтой байлаа. Сургалтад хамрагдсанаар худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэн илүү үр ашигтай, ил тод, хариуцлагатай зохион байгуулах мэдлэг, чадвар, туршлагыг эзэмшсэн гэж үзэж байна.

Сургалтад хамрагдсан албан хаагчдын нэрс болон зургийг хавсаргав.

Тайлан гаргасан:

Төрийн захиргааны удирдлагын газрын
Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн
ахлах мэргэжилтэн



Ц.Халиун

Хавсралт:

Сангийн яамнаас зохион байгуулсан худалдан авах ажиллагааны сургалтын үеийн гэрэл зураг (2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны хүндэтгэлийн танхимд авсан)

